

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

ГАЗАР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

“19.7. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зарим нэгжийн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэсэн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сум хоорондын хилийн цэсийн эргэлтийн “Хонгорын даваа” цэг болон Архангай аймгийн Хайрхан сум, Булган аймгийн Сайхан сум хоорондын хилийн цэсийн эргэлтийн “Өргөөт” цэгийг тухайн хилийн цэсийг тогтоосон архивын баримт материал, зураглалд үндэслэн, Ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т, тухайн сумдын хилийн цэсийн талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгч, мөрдүүлж ажиллахыг Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай, Булган аймгийн болон холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгов;

2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтооцыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР